

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
ДОТООД ХЯНАЛТ-АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ГАЗРААС 2025 ОНЫ ЭХНИЙ
ХАГАС ЖИЛИЙН БАЙДЛААР ХИЙСЭН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

2025.06.24

Улаанбаатар хот

Цагдаагийн ерөнхий газрын даргын баталсан хяналт шалгалтын 2025 оны төлөвлөгөөний дагуу Дотоодын цэргийн штаб, Баянзүрх, Хан-Уул дүүрэг, Дундговь аймгийн цагдаагийн газар, Говь-Сүмбэр аймгийн цагдаагийн хэлтэст төлөвлөгөөт бүрэн, Нийслэлийн цагдаагийн удирдах газар, Сүхбаатар дүүргийн цагдаагийн газар, Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төв, Хөвсгөл, Увс аймгийн цагдаагийн газарт гүйцэтгэлийн шалгалт явуулах төлөвлөгөө, хуваарийг батлуулан, анги, байгууллагад хүргүүлж, энэ оны эхний хагас жилийн байдлаар батлагдсан хуваарийн дагуу 3 удаа (Дотоодын цэргийн штаб, Говьсүмбэр аймгийн цагдаагийн хэлтэс, Хан-Уул дүүргийн цагдаагийн газар) төлөвлөгөөт бүрэн шалгалт, 3 удаа (Нийслэлийн цагдаагийн удирдах газар, Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төв, Увс аймгийн цагдаагийн газар) гүйцэтгэлийн шалгалтыг явуулж, дүнг удирдлагад танилцуулсан ба гарсан шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллах, шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах чиглэлээр 4 удаа 73 заалттай албан даалгаврыг хүргүүлэх зэрэг ажлуудыг хийсэн, төлөвлөгөөний биелэлт **60.0 хувьтай** хэрэгжсэн байна.

Түүнчлэн иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж цагдаагийн алба хаагч, байгууллагын үйл ажиллагаатай холбогдуулан гаргасан гомдлын хүрээнд удирдлагын шийдвэрээр Мөрдөн байцаах албаны Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, Тусгай субъектээс үйлдсэн гэмт хэрэг, Залилах гэмт хэрэг мөрдөн шалгах хэлтэс, Баян-Өлгий, Хэнтий, Увс, Орхон аймгийн цагдаагийн газар, ЦЕГ-ын Захиргааны удирдлагын газрын Зохион байгуулалтын хэлтэс, Сургалтын бодлого, зохицуулалтын хэлтсийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус хэсэгчилсэн шалгалтыг явуулж, дүнг удирдлагад танилцуулан шийдвэрлүүлсэн.

Цаашид хэрэгжүүлэх ажил:

Дээд шатны байгууллага, албан тушаалтны баталсан төлөвлөгөө, хуваарийн дагуу сүүлийн хагас жилд нийт 4 нэгж (Баянзүрх, Сүхбаатар дүүрэг, Дундговь, Хөвсгөл аймгийн цагдаагийн газар)-ийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хийхээр төлөвлөсөн ба 2025 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний хэрэгжилт 100 хувь хангагдана гэж үзлээ.

ДОТООД ХЯНАЛТ-АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ГАЗАР

